5.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:44/

6.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:44/

7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:44/

8.Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:44/

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

9.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:44/

10.Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:44/

11.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:45/

12.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:45/

13.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:45/

14.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:45/

15.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:45/

16.Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:45/

17.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:45/

18.Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:45/

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

19.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:45/

20.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:46/

21.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:46/

22.Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:46/

23.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:46/

24.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:46/

1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:46/

Дагалдан гарсан:

2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:46/

3.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:47/

4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:47/

5.Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:47/

6.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:47/

7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:47/

8.Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:47/

9.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:47/

10.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:48/

11.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:48/

12.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:48/

13.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:48/

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

14.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:48/

15.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:48/

16.Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:48/

1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:48/

Дагалдан гарсан:

2.Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:49/

3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:49/

4.Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:49/

Холбогдуулан боловсруулсан:

5.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:49/

1.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:49/

Дагалдан гарсан:

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

2.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:49/

3.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:49/

4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:50/

1.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./13:50/

1.“Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./13:50/

Уг асуудлыг 13 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа

Хуралдаанд Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, дэд дарга Ц.Батбаатар, Дотоод аудитын албаны дарга бөгөөд дотоод аудитор Я.Баттогтох, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга А.Энхзул, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Жамбалдорж, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, Цахим парламент, инновацын газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Пүрэвдагва, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын Олон нийттэй харилцах хэлтсийн дарга Б.Батманлай, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганыг хааж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Төрийн дуулал эгшиглэхэд Улсын Их Хурлын гишүүд болон хаалтын ажиллагаанд оролцогчид босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулган хаасныг мэдэгдэв.

Бусад. Монгол Улсад айлчлал хийж буй Бүгд Найрамдах Энэтхэг Улсын парламентын Лок Сабхагийн дарга Ом Бирла тэргүүтэй төлөөлөгчид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 30 минут үргэлжилж, 73 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 87.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их Хуралдай” танхим
10 цаг 11 минут.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн амрыг эрье.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нийтдээ 6 асуудал хэлэлцэнэ.

1. Хууль, тогтоолын төсөл эцэслэн батална. Нийтдээ 140 төсөл байгаа.

2 дугаарт нь, “1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашиунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

3-д, “Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцүүлнэ. Эцсийн хэлэлцүүлэг.

4-д, Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал байна.

5-д, “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

6-д, Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы хаалт байгаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирсэн албан бичгийг танилцуулъя.

Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай. Албан ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулж өгөхийг хүсье гэсэн байна. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалан даргаас ирсэн албан бичиг байна.

Ингээд дарааллаас энэ мэдээллийг хасаж байна.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужин, Бөхчулууны Пүрэвдорж, Даишдондогийн Ганбат, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нараас албан бичгүүд ирүүлсэн байна. Танилцуулъя.

Хүсэлтийг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар Танаа. Хүсэлт гаргах тухай. Миний бие Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу 2023 оны хаврын ээлжит чуулганы 07 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх тул зөвшөөрөл олгож өгөхийг хүсье. Улсын Их Хурлын гишүүн Анужин гэсэн байна.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Анужсин гишүүн яах юм. Анужсин гишүүн үгээ татсан байна.

Дараагийн гишүүний хүсэлтийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж. Миний бие 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж үг хэлье.

Б.Пүрэвдорж: Тун удахгүй дэлгэр сайхан наадам болж, Монголчууд хотол олноороо баярлах гэж байна. Энэ баярын босгон дээр Монгол Улсын Засгийн газрын өргөн барьснаар, мөн түүнчлэн бидний нөхдийн өргөн барьсан Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Нийгмийн даатгалын багц хууль, мөн бидний өргөн барьсан 7 жилээр биш 5 жилээр тэтгэвэр тогтоох, мөн 2018 оноос хойш 7 жилээр тэтгэврээ бодуулсан тэр хүмүүсийг нөхөн бодох зөрөө болгох энэ хуулийн төслийг хэлэлцэж баталлаа. Гэхдээ энэ хууль тийм амар яваагүй.

Засгийн газраас өнгөрсөн онд бүр 7 биш, бүр 10 болгохоор хууль оруулж ирсэн гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Үүнийг ахмадууд маань 11 сард жагсаал хийж байж буцаасан. Түүний үр дүнд Засгийн газраас дахин Нийгмийн даатгалын багц хуулийг оруулж ирж, 5 жил болгох энэ агуулгыг оруулж ирсэн байгаа.

Мөн түүнчлэн 6 сард бас дахин жагсаал хийж, энэ хуулийг батлуулахаас өөр аргагүй болгосон ахмадууддаа бас талархал илэрхийлье. Энэ хугацаанд энэ хуулийг батлуулахын тулд нийтдээ Монгол Улсын 19 аймгийн 40 гаруй сумд очиж ажилласан байна. Улсын Их Хурлын индэр дээрээс яг өглөөний хамгийн их эрт цаг аваад 60 гаруй удаа

үг хэлсэн байна. Энэ тэмцлийн маань үр дүнд энэ хууль өнөөдөр эцэслэн батлагдаж байгаад маш их баяртай байна.

Тэгэхдээ бас энэ хуулийг батлахад бас зарим нэгэн асуудал үлдсэн байгаа. Өөрөөр хэлбэл 2018 оноос хойш нийтдээ 58 мянган иргэн 91 тэрбум төгрөгөөр хохирсон байгаа. Нэг хүнд дунджаар 1,5 сая төгрөгийн хохирол учирсан байна. Тийм учраас энэ зөрөөг буцааж олгох талаар цаашидаа ажиллах болно. 2024 оны төсвийг энэ оны 11 сард хэлэлцэх үед энэ хөрөнгийг тусгах талаар ажиллах болно. Манай ахмадууд итгэл найдвараа алдалгүй хүлээж байгаарай. Тэгээд ирэх жилийн наадмаараа зөрөөгөө авсан, хэн хэндээ асуудалгүй, амьд бурхад болсон ахмадууд маань сайхан баярласан ийм баярыг үзнэ ээ, угтана гэдэгт эргэлзэхгүй байна.

Тэгээд Монголынхоо нийт ахмадууддаа, Монголчууддаа дэнж хотойтол сайхан баярлахын ерөөлийг өргөн дэвшүүлъя.

Л.Мөнхбаатар: Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлье.

Д.Ганбат: Өнөөдөр ингээд 6 асуудал хэлэлцэх юм байна. Ингээд хаврын чуулганы хаалтын өдөр байна. Гэхдээ би нэг юм хэлэхгүй бол болохгүй юм байна гэж ойлгоод байна шүү дээ. Би энэ улс орон авлигад аажим живж байгаа усан онгоц шиг байна гэдгийг удаа дараа энэ 3 жил сануулж байсан. Гэтэл үүний дагуу арга хэмжээ авч байсан юм ерөөсөө алга. Хэдийгээр сайн сайхан байгаа юм шиг хурал зөвлөгөөнөө хийгээд, ингээд худлаа амлалтуудаа яриад, ингээд яваад байсан боловч өнөөдөр 2, гуравхан хоног зүгээр нэг шиврээ бороо л орлоо шүү дээ.

Улаанбаатарт. Бороо ороосой гэж ард түмэн хүсэж байлаа. Хуртай сайхан наадам болоосой гэж хүсэж байсан. Гэтэл энэ удаа тийм биш байна.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Өчнөөн мянган айлууд гэрэл цахилгаангүй байж байна. Өчнөөн мянган айлууд гэр орондоо хонож чадахгүй байна. Нөгөө эрдэмтэн зохиолч Түдэв гуай хэлж байсан шүү дээ. Одоо дээрээс нь хамаг өтгөн шингэн, хамаг юмаа энэ нэг хэдэн хүн гоожуулаад л байж байхад хүлцэнгүй энэ нь ингээд тэсвэрлээд байдаг энэ Монголын ард түмэн үнэн хөөрхийлөлтэй юм гэж байсан. Үгүй ээ, түүнийг нь одоо тийм байна гэдэг нь яг өчигдрийн байдлаар ингээд ил гарч байна шүү дээ. Энэ Монголын хүн амын 50 хувь нь оршдог Улаанбаатар хот маань улсын нийслэл маань тэр өтгөн шингэнийхээ юманд холилдоо шүү дээ. Энэ бол зүгээр голын үе урсгал биш юм. Энэ Монгол Ардын нам буюу Монголын авлигачдын намын өтгөн шингэнээ гоожуулж байгаа энэ хэлбэр нь үүгээр гарч илэрхийлж байгаа юм. Юун баяр, юун наадам. Энэ гэрэлгүй цахилгаангүй энэ хүмүүс чинь зурагтаа ч асаагаад та бүхний тэр баян цатгалан энэ юмыг чинь харж чадахгүй нь байна шүү дээ. Тэгээд бид нар юу ч болоогүй юм шиг ингээд цааш нь үргэлжлүүлээд явж болохгүй байна. Энэ бид нарыг завсарлаж байгаа хугацаанд ямар ч юм болж магадгүй шүү дээ. Энэ байдлыг нь харж байхад. Энэ хот чинь, энэ улс орон чинь энэ юманд бэлтгэлгүй байна шүү дээ. Түүнийг бүгдээрээ л харлаа, Монгол даяараа.

Тэгэхээр энэ асуудлыг бид нар өнөөдөр авч хэлэлцсэн нь дээр байх. Яагаад ийм байдалд орсон юм. Өчнөөн их наядын төсөв тавьчхаад байхад энэ олон жил яагаад ийм бэлтгэлгүй байдаг юм. Тэр авлига хороолол гээд бүхэл бүтэн байшингууд нэртэй устайгаа бичигдчихсэн ийм байдалтай байна. Тэгээд түүндээ шүүгчдийг буруутгаад л, шүүгчид буруутай нь буруутай л байх. Тэр бол та бүхний эрх баригчдын дохио зангаагаар ажилладаг ийм л болчихсон шүүх шүү дээ.

Бид нар хотын мээрийг ард түмнээсээ сонгодог болгож болно шүү дээ. Ихэнх ардчилсан улс орнуудад тийм

л байдаг. Гэтэл тэгээд амралтаараа нэг амрах гэсэн хэдэн оюутан, сурагчид, залуучуудыг буруутгаад л, тэр play time-д явлаа гэх шиг. Үгүй ээ, бас ингэж байж болохгүй. Уул нь хамгийн эрх мэдэлтэй, хамгийн мөнгөтэй ийм Засгийн газар байгаа. Энэ Улаанбаатар хотоос чинь Монгол Ардын намын Улсын Их Хурлын гишүүд бүгдээрээ л байгаа биз дээ. Аялдан дагагчид нь тэр охин намтайгаа нийлээд бүгдээрээ л байгаа. Нэг ардчиллын гэмээр хүн ганц ч байхгүй шүү дээ. Тэгээд л бүгдээрээ дув дугуй, амандаа бүлх залгисан юм шиг ингэж чимээгүй байж байх юм.

Цаана чинь ард түмэн үнэхээр үйлж байна шүү дээ. Хэлье ээ тэнгэр хол, газар хатуу ийм байдалтай байхад зүв зүгээр юу ч болоогүй юм шиг ийм байдлаар ингэж өнгөрөөж болохгүй. Энэ Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага нь энэ Улсын Их Хурал юм бол энэ асуудлыг яаралтай авч хэлэлцье. Би ийм саналыг оруулж байна.

Өнөөдөр тэгс ингэс хийгээд хаагаад явчихмааргүй байна. Одоо ер нь үзэн ядаж байна шүү дээ. Хуучин бол одоо авлига гэдэг чинь тэр дээгүүрээ хуваагаад авчихдаг юм байгаа биз, бид нарт ямар хамаа байна вэ гэсэн байдалтай хардаг байсан бол авлига яаж нөлөөлдгийг энэ Улаанбаатар хотын өнөөдрийн нөхцөл байдал харуулж байна шүү дээ. Энэ бүхнийг бага ч гэсэн засаж залруулахын төлөө хэдүүлээ бас нэг ажиллавал яасан юм бэ гэдэг саналыг би тавьж байна.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд, би хотоос сонгогдоогүй л дээ, гэхдээ би бас хотын иргэн, иргэн хүнийхээ хувьд хэлж байна. Ард түмнийхээ элчийн хувьд хэлж байна. Ингээд хөлдүү царайлаад байгаад байгаа юм байхгүй, та нар. Цаана чинь нэг хүн хүнд хэцүү ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Дараагийнхаа асуудалд оръё.

Хуулийн тогтоолын төслийг эцэслэн батална.

Одоогоор 39-өөс дээш гишүүний ирцтэйгээр батлах ёстой. Энэ асуудлыг түр хойшлуулж байгаад 2 дахь асуудлаа хэлэлцье.

“1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганц мод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хороо тус тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд, чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрөөтэй саналын томъёоллуудыг тогтоолын төсөлд нэг

бүрчлэн тусгаж, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрөөтэй саналуудыг нэмж тусгасан эцсийн хувилбарын төсөл, тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганхуяг гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

“Эрдэнэс тавантолгой” компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Эрдэнийн Түвшинжаргал, “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн Маркетинг борлуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Баянгийн Серикжан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Лувсанцэрэнгийн Пүрэвсүрэн нар оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй. Ганбат гишүүнээр тасаллаа. Дашдондогийн Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Ингээд 55 оны гэрээ гэж байна. Гашуунсухайт, энэ боолтыг БНХАУ-тай ингээд холбох гэж байгаа юм байна. Өмнө энэ төмөр зам чинь хэзээ баригдлаа, яагаад холбогдохгүй байсан юм бэ? Одоо ингээд эрх барьж байгаа нам маань 8 жил эрх барьж байна, 7 жил эрх барьж байна. Яагаад энэ холболтыг хийхгүй ингэж удаасан юм бэ? Ямар учир шалтгаанаар? Хэрвээ энэ сүүлийн 7, 8 жил бол эрчим хүч, энэ уул уурхайн бүтээгдэхүүний супер циклийн үе байлаа. Мааш өндөр үнэтэй ийм боломжтой үеүд байсан. Үүнийг бараг л албаар саатуулж байгаа юм шиг ийм бодлого явуулсан байна, энэ 7 жил. Хэрэв эндээс орж ирсэн алдагдсан боломж гэж байгаа, энэ алдагдсан боломжоор бараг 80 их наяд гэсэн үү, тийм мөнгө нь орж ирсэн бол энэ улс орон ямар байх байсан бэ? Тухайлбал Улаанбаатар хот маань ямар байх байсан бэ. Зориуд үүнийг ийм байдалтай болгож, энэ улс орныг хөгжүүлэхгүй, энэ Улаанбаатар хотыг энэ авлигачдын үүр уурхай болгож ингэж явсан чинь ямар учиртай юм бэ. Одоо энэ ажлын хэсэг энэ тогтоолын төсөл санаачилж байгаа Засгийн газар энэ бүхэндээ судалгаа хийсэн үү, дүн гаргасан уу, дүгнэлт хийсэн үү, дүгнэлт хийгээд, судалгаа гаргаад ингэсэн бол ямар судалгаа, ямар дүгнэлт хийсэн юм бэ? Энэ бүх өнгөрсөн хугацааны хариуцлагыг олонх байснаараа та нар маань хүлээх үү? Би Монгол Ардын намыг яриад байна л даа. 65, 62 суудалтай байсан.

Энэ улс орныг ийм 8 жил, бараг дэлхийгээс тусгаарласан шахуу байдалтай, ямар ч ач холбогдолгүй төмөр замуудыг маш их мөнгөөр барьж байгуулчхаад энэ юм чинь ингээд л зүгээр л байдгаараа байгаад өнгөрөх үү. 2014 онд бид нар нарийн царигтай олон улсын царигтай төмөр зам байлгая. Энэ бүгдийг холбоод хувийн хэвшил нь хийгээд явж байя гэсэн ийм шийдвэрүүд гарч байсан. Энэ ямар учиртай өөрчлөгдөөд, ямар маягтай ингээд цаашаа яваад

байсан юм бэ гэсэн ийм юман дээрээс энэ дүн, дүгнэлт хийсэн зүйл байна уу.

Одоо тэгээд энэ чинь холбогдоод ингээд явахаараа удахгүй бүх нийтээрээ дэлхий нийт чинь ногоон эдийн засагт шилжиж байна. Тэгэхээр энэ эрчим хүчний эх үүсвэр болсон, тухайлбал дан айл болгон хэрэглэдэг байсан энэ нүүрс эд нар чинь бас арай өөр замаар, арай өөр маягаар орж магадгүй шиг байна.

Энэ бүхэн дээр та бүхэн судалгаа шинжилгээ хийсэн үү, яасан, хэзээ энэ чинь орох юм бэ гээд тэр түрүүн яриад байгаагаар бол 2, 3 жилийн дараа л гэж байна. Бас л нөгөө нэг газрын тосны үйлдвэр шиг тэр маягаараа 10, 20 жил болчихсон, ахиад л баахан тэр лүүгээ мөнгө цутгасан. Ийм нөхцөл байдалтай болно, болохгүй гэсэн баталгаа байна уу гэсэн ийм зүйлүүдийг бас тодруулмаар байна, асуумаар байна. Үүнийг бас Монголын ард түмэн мэдэх эрхтэй гэж бодож байна. Тийм.

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатар хариулъя.

Х.Нямбаатар: Би тогтоолын төсөл санаачлагчийн хувьд Ганбат гишүүний асуултад би маш тодорхой хэдэн хариулт өгье. Энэ төмөр замын маш их нарийн хийцлэлтэй ийм төмөр замын бүтээн байгуулалт, хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажил хийгдэх юм. Адаглаад бетон цементийнх нь бэхжилтийг авахад жил гарнаас наашгүй ийм хугацаатай. Зүгээр нэг энгийн 40-ийн бетон цутгах гэж байгаа юм шиг тийм хурдан хийгдчихгүй ажил. Тэгээд би танд тийм. Тэгэхээр энэ бол нэг ойролцоогоор ТЭЗҮ-д дурдсанаар нэг 1,6 жилдээ багтааж хийе ээ гэдэг ийм юутай байгаа.

Тэгэхээр та буруутныг их ойрхноосоо хайх хэрэгтэй, Ганбат гишүүн ээ, би танд тодорхой хэлье. Тантай Баянхонгор аймгаас хамт

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

сонгогдож, сүүлд Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Халтмаагийн Баттулга гэдэг хүн төмөр зам барьж, хил дамнасан төмөр зам баривал танк орж ирээд Хятадууд бид нарыг эзэлнэ гэдэг пробогандаа хийхэд та ард нь алга ташаад явж байсан хүн. Яг энэ супер циклийг тэр үед бид нар алдсан. Монгол Ардын нам сүүлийн 7 жилийн хугацаанд Зүүн төмөр зам Гашуунсухайтын төмөр зам гээд энэ төмөр замын ажлуудыг барьж байгуулаад бид нар хил холболтыг хийх гэж байна. Тэгээд би зүгээр Ганбат гишүүнийг улс төржчих гэж байгаа бол би ч гэсэн тан шиг сүрхий юмнууд ярьж чадна. Тантай хамтран зүтгэж Баянхонгор аймгаас хэд хэдэн удаа сонгогдсон экс Ерөнхийлөгч маань энэ төмөр замын ажлыг Зам тээврийн сайд байхдаа төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэх гэж байхад нь зогсоож байсныг Монголын ард түмэн мэдэж байгаа.

Хэрвээ хилээр төмөр замаар түүхий эдээ зөөгөөд эхэлбэл энэ түүхий эд чинь гялгар уутанд хийсэн элс шиг асгараад бид нар маш хурдан баялгаа алдаж дуусах гэж байна. Төмөр зам баривал танк орж ирнэ гэдэг ийм суртал ухуулгын нэвтрүүлгүүдийг явуулж байсныг та мэдэж байгаа. Тэгэхээр эзнийг та өөрийнхөө нутгаас очиж хайх нь зөв байх гэж бодож байна. Юм хийх гэж байгаа хүмүүст дандаа ийм нэг хэгийн чөдөр тушаа болдгоо боль оо. Улс төржих үедээ улс төрж. Би танд өшөө ярих хариултууд бэлэн байгаа шүү.

Л.Мөнхбаатар: Тодруулах шаардлага байгаа юм уу даа, та 2 улс төржөөд байх юм. Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Яах вэ, Нямбаатар гишүүн жоохон бухимдалтай байх шиг байна, сайд. Тэр бетон зутгадаг үгүй 2-ыг мэдэхгүй юм, тэрийг сайн лавлаарай. Юу шүү. 2014 онд бид нар олон улсын цариг барья, байгуулъя гээд Ардчилсан нам олонх биш, олон байхдаа баталж

байсан юм. Түүний нэг нь би шүү. Гэтэл хэдэн ч удаа өөрчлөгдөөд яадаг юм. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийг та нар буруутгаад байх юм байхгүй. Монгол Улсын Ерөнхийлөгч гэдэг бол аж ахуйн ажил хийдэг хүн биш. Засгийн газар олонх та нар л байсан юм шүү дээ. Улсын Их Хурал хуулиа батлаад, тогтоол шийдвэрээ батлаад л явдаг. Ер нь Ерөнхийлөгч нар бол энэ ажилд над байхгүй шүү дээ. Хэрэв та нар тэгж дүрвэлзэж байсан бол та нар өөрсдөө буруутай. Та нар өөрсдөө очиж тэр сайн сайхан юм болохоор та нар өөрсдөө нэр нүүрээ наадаг, болохгүй юм болохоор бусад руу чихдэгээ боль оо. Тийм л байсан юм бол тухайн үед нь та нар тэгээд хэлээд ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Манай Ганбат гишүүн маань асуудлынхаа голыг өмнөх парламентад 3 секундэд багтаагаад базаад хэлчихдэг байсан. Одоо жаахан урт хэлдэг болчихоод байгаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

“1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт- Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд суугаарай. Санал хураалт.

67,3 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

10.36 цаг

Дараагийнхаа асуудалд орёе.

“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын 2022 оны хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцтай танилцах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 162 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд тус ажлын хэсгийн танилцуулгыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр хуралдаанаараа сонсож, Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хангуулах чиглэлээр “Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо боловсрууллаа.

Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг явуулж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хорооны 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг төслийн 1 дэх заалтын хугацааг өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасныг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан санал хураалт явуулахад, хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй саналаар дэмжсэн.

Тогтоолын төслийн эцсийн хувилбарын төсөл болон Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн

зарчмын зөрүүтэй саналын томъёолол, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганхуяг гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая. Зарчмын зөрүүтэй 1 санал байна. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн санал хурааж, дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр заалтын 1 дэх дэд заалтын “06 дугаар” гэснийг “10 дугаар” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

64 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Одоо хууль, тогтоолын төслийг эцэслэн батална. Гишүүд байраа эзэлье.

“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төсөл баталлаа. Тогтоолын төсөл батлагдлаа.

Энэ дээр санал хураах юм уу. Саналын томъёоллоор санал хураачихсан юм чинь тогтоолын төсөл батлагдлаа гээд явчихдаг шүү дээ. Заавал санал хураалт явах юм уу, тийм ээ.

Тэгвэл санал хураалтыг явуулъя. Тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт, гишүүд ээ.

66 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

10.41 цаг

Дараагийнхаа хэлэлцэх асуудалд оръё.

Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д 7 хоногийн Баасан гарагийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулна гэж заасан. Энэ заалтын дагуу санал хураалтуудыг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-д нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Энэ дэгийн тухай санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

1. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг

эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт, гишүүд ээ.

72 хувиар санал. Хэн санал гаргах юм. Раднаасэд гишүүн горимын санал гаргая.

Ш.Раднаасэд: Энэ дохионоос өмнө санал хураалтад оролцсон, аппарат эсрэг гарчихлаа. Дахин санал хураалт явуулж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Раднаасэд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

67,3 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүйд тооцлоо.

Гишүүдийг, намын бүлгүүд ирцээ бүрдүүлъя.

Сая санал хүчингүйд тооцсон байгаа. Санал хураалтыг түр хойшлуулаад дараагийнхаа асуудлыг хэлэлцэж байя.

Энд зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлаа хэлэлцэх үү?

Дараагийн асуудлыг хэлэлцье.

Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмааг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгаланг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Салдангийн Одонтуяаг Улсын Их Хурлын Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр баталсугай.

3. Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төслийг уншиж танилцууллаа. Санал хураалт явуулъя. санал хураалт.

80,4 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолын төсөл дээр эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.47 цаг

Хууль, тогтоолын төслөө эцэслэн батлах санал хураалтыг явуулъя.

Иргэний нисэхийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт, гишүүд ээ.

80,4 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Иргэний нисэхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

80,8 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл эцэслэн батлагдлаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн горимын санал гаргая.

Ц.Даваасүрэн: Уучлаарай, техникийн алдаа гаргачихлаа. Дахин санал хураалт явуулж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Энэ хүчингүй болсон, санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Үндсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт, гишүүд ээ.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5. Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

8. Монгол Улсын Хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ дээр үү. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Хэн горимын санал гаргах юм. Энхтүвшин гишүүн горимын санал гаргая.

Т.Энхтүвшин: Уучлаарай, сая дарсан боловч эсрэг санал гарчихлаа. Дахин санал хураалт явуулж өгөөч.

Л.Мөнхбаатар: Энхтүвшин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энхтүвшин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан, санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

томъёоллоор санал хураалт явуулъя.
Санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

18. Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ яагаад юу яачхав. Шууд дахиж санал хураалт явуулах уу, хүчингүй болгох уу. Хүчингүй болгох санал хураалт. Санал, горимыг Лхагвын Мөнхбаатар Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн.

Л.Мөнхбаатар: Саналыг дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй. Санал хураалтыг дахин явуулж өгнө үү.

Г.Занданиатар: Мөнхбаатар гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

45 гишүүн дэмжиж, 83,3 хувийн саналаар санал хураалт хүчингүйд тооцлоо. Санал хураалт хүчингүй болсон тул 18 дахь санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааръя.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

19. Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

20. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

21. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Санал хураалт. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Санал хураалт. Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

24. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараа нь эцэслэн батална.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Дараа нь төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

46 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт дахиад явна. 8, саяын унисан.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

10. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Дараа нь Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явууллаа.

Дараа нь Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

12. Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах. Санал хураалт.

Дараа нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. 38-аар батлагдах билүү, хэн горимын санал.

Дамбын Батлут гишүүн.

Д.Батлут: Саяын санал хураалт дээр дэмжиж санал өгсөн боловч тоног төхөөрөмж ажилласангүй. Тэгээд энэ саналыг хүчингүй болгож, дахин санал хураалгаж өгнө үү.

Г.Занданшатар: Горимын саналаар санал хураалт явуулъя.

76,4 хувийн саналаар санал хураалт дэмжигдэж, горимын санал дэмжигдэж санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Тийм учраас санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төрийн хянан шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

Энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт. Горимын санал гаргаж дахин явуулъя. Санал хураалт. Горимын саналаар санал хураалт явуулж байна. Горимын санал гаргасан, хүчингүйд тооцох санал хураалт.

56,4 хувийн саналаар энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалт дахиж явуулна. Санал хураалт. Ганболд гишүүн ээ, Адьяасүрэн гишүүн.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Санал хураалт. Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Намайг санал хураалт гээд цохихоор энэ юугаа явуулаад байгаарай. Санал хураалт. Алдар цолтой ахмад настанд төрөөс нэмэгдэл хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулж байна.

Энэ санал хураалтын хонхоо дуугаргамаар байна. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалтын хонхгүй явчихсан. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцсон

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

учраас ахиж санал хураалт явуулна. Энэ санал хураалтын хонх яагаад дуугарахгүй байна.

47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Дараагийн багц хууль нь. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

48 гишүүн дэмжиж, эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Санал хураалт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хуулийг хүчингүй болсонд тооцсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

51 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Тэр хуулийг уул нь батлах ёстой байсан. 50 гишүүн дэмжиж, хуулийн төслийн батлагдлаа.

Эцэслэн батлах санал хураалт. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эцэслэн батлах санал хураалт. Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эцэслэн батлах санал хураалт. Төрийн шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулж байна.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Дагалдан гарсан Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

3-д, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

50 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5. Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5. Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

50 гишүүн дэмжиж, 46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг сая явуулсан.

Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн

баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

49 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

7. Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Холбогдуулан боловсруулан “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Тогтоол батлагдлаа.

1. Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Сайд нь байхгүй юм чинь хойшлуулах уу? 2 цаг аа. Мөнхцэцэг, Дамдинням 2-ыг.

Хамт өргөн мэдүүлсэн Боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Сургууль өмнөх боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулсан. 48 гишүүн дэмжиж батлагдсан.

Бага, дунд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

50 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эцэслэн батлах санал хураалт. Дээд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт. Дээд боловсролын санхүүжилт суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай.

43 гишүүн дэмжиж, хуулийг эцэслэн батлагдлаа.

Эцэслэн батлах санал хураалт. Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим хэсэг заалтыг хүчингүй болсонд тооцох тухай

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт. Гамигаас хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай.

50 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

50 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эцэслэн батлах санал хураалт. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

12. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим заалт, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

13. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

14. Мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөлд бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

15. Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Ойн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

17. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

17. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална.

18. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

20. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эрүүл ахуйн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя, сая эцэслэн баталлаа.

24. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

1. Сургуулийн өмнөх ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

44 гишүүний дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Багийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

49 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

10. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

11. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хууль дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

50 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

49 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

51 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зочид танилцуулъя.

Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаа Бүгд Найрамдах Энэтхэг Улсын парламентын Лок Сабхагийн дарга Ом Бирла тэргүүтэй төлөөлөгчид Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцаж байна. Бидний урилгыг хүлээн авч Монгол Улсад зочлон ирсэн Бүгд Найрамдах Энэтхэг Улсын парламентын Лок Сабхагийн дарга Ом Бирла Танд болон Раджа Сабха, Лок Сабхагийн эрхэм гишүүд, төлөөлөгчид та бүхэнд Монгол Улсын Их Хурлын

нэрийн өмнөөс болон хувиасаа гүн талархал илэрхийлье.

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулган хаалтын хуралдаанаа хийж байгаа 07 дугаар сарын 07-ны өдөр хийж буй таны энэ айлчлал, энэ өдөр Үндэсний их баяр наадмын босгон дээр хүндэт зочин, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын парламентын Лок Сабхагийн дарга Ом Бирла Таныг Монгол Улсад, Монгол Улсын Их Хуралд хүлээн авч байгаадаа бид туйлын их баяртай байна. Оюун санааны хөрш гэж үздэг Бүгд Найрамдах Энэтхэг Улстай хөгжүүлж байгаа харилцаа, хамтын ажиллагаа, түүхэн болон соёлын хэлхээ холбоо, ардчиллын нийтлэг үнэт зүйлс, бүс нутаг болон олон улсын энх тайван тогтвортой байдлыг сахин хамгаалах 2 талын хүсэл эрмэлзэлд суурилан стратегийн түншлэлийн зарчмаар тууштай өргөжин хөгжиж байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Манай улсын гадаад бодлогын үзэл баримтлалд заасны дагуу манай гуравдагч хөрш ч дэлхийн хамгийн том ардчилсан орон Бүгд Найрамдах Энэтхэг Улстай хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын зүгээс өндөр ач холбогдол өгч, цаашид боломжит бүхий л чиглэлээр харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө байгааг энэ таширамд тэмдэглэн хэлье.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Лок Сабхагийн дарга Ом Бирла Таны Монгол Улсад хийж буй албан ёсны энэхүү ажил нь 2 улсын уламжлалт найрсаг харилцаа, түүний дотор парламент хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэхэд чухал түлхэц үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Эрхэмсэг Ноён дарга таны айлчлалд амжилт хүсэхийн ялдамд Танд болон Раджа Сабха, Лок Сабхагийн эрхэм гишүүд, төлөөлөгчид та бүхэнд

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс болон хувиасаа хүсэн ерөөе.

Бид нар хуулийн төслөө эцэслэн батлах ажиллагаагаа үргэлжлүүлэе.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Улс төрийн намын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль гэсэн батлагдлаа.

Манай Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нийт гишүүдийн олонх нь хуулийг эцэслэн баталж байж хууль батлагддаг болсон болохыг эрхэм зочдодоо танилцуулъя. Нийт гишүүд 76 гишүүнтэйгээс 39-өөс дээш гишүүн гэж эцэслэн баталдаг.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн

баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эрхэм зочдодоо танилцуулахад энэ хурууны хээгээ уншуулж санал өгдөг байгаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Сая арга хэмжээ, санал хураалт 2 давхацсан учраас энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Алх цохигдоогүй, хонх дуугарагдаагүй учраас. Санал хураалтыг дахиж явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Энэ цаанаас нь гарч ирээд л байх юм.

7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн, хураачихсан сая.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Шүүхийн тухай хуулийг хураачихсан.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

10. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

12. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд анхааралтай, одоо цөөхөн үлдэж байна шүү.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөөе, хөөе Адьшаа гишүүн ээ, хөөе, хөөе та хэд, Цогтгэрэл дарга яачхав аа.

Хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Сая хонх дуугарахгүй байж байгаад энэ хоцроод ажилласангүй. Санал хураалтыг дахиж явуулъя. Хөөе, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, хөөе Энх-Амгалан, хөөе Энх-Амгалан сайд. Санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалтыг дахиж явуулъя. Гишүүд ээ, анхааралтай байгаарай. Арга хэмжээ авъя. Санал хураалтыг дахиж явуулъя, гишүүд. Санал хураалтыг дахиж явуулна.

Санал хураалт, анхааралтай. Санал хураалтыг дахиж явуулж байгаа шүү, хонх дуугарлаа.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Чинзориг сайдын хууль шүү, энэ. 1. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал

хураалт. Гишүүд анхааралтай, санал хураалт.

Дэлгэрсайхан гишүүн, Борхуугийн Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Сая би дэмжсэн санал өгсөн боловч миний төхөөрөмж ажилласангүй. Тэгээд дахин санал хураалгаж өгнө үү.

Г.Занданшатар: Бейсен гишүүн бас адил горимын саналтай гэж ойлголоо. Та 2-ын горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

74,1 хувийн саналаар санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

76,4 хувийн саналаар санал дэмжигдэж байна. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

3. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын дүгнэлтээр санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эцсийн найруулга дээр саналаа өгчих.

6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын дүгнэлт санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Энэ чинь төсвийн хууль шүү дээ. Энэ Тэмүүлэн нарын гишүүдийн, төсвийн реформын хууль шүү, энэ чинь.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Тогтохсүрэн дарга, Туваан гишүүн ээ, санал.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлтэд оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Ирээдүй өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Ирээдүй өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

12. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

13. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хуулийн төслийг, тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Энэ тогтоолын хууль гэж яагаад биччихсэн юм. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Тогтоол эцэслэн батлагдлаа.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Тогтоол эцэслэн батлагдлаа.

Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Сүүлийн санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн баталлаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн хэлэлцэх асуудалд орно.

“1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр. Ярьчихсан уу. Хуулийн хэрэгжилтийг хангах. Явчихсан уу?”

12.08 цаг

5 дахь асуудалд оръё.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна.

Гишүүдэд Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд гараа өргөөдхөөч. Үүний дараа Эзэн Чингис хааны танхимд Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдана. Тэгээд дараа нь чуулганы хаалттай.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын

чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулж, 2023 оны 07 сарын 05-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо намын бүлэг, Байнгын хороо, хууль санаачлагчийн саналыг үндэслэн дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батлах зохицуулалтын дагуу Байнгын хорооноос 51, Монгол Улсын Засгийн газраас 106, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс 27, Ардчилсан намын бүлгээс 27, Улсын Их Хурлын гишүүнээс 2 санал ирсэн бөгөөд давхардсан тоогоор нийт 213 хууль, тогтоолын саналыг авч хэлэлцсэн.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоол, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол, “Шинэ сэргэлтийн бодлого бодох тухай” Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 23 оны 44 дүгээр тогтоол болон батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан хууль, тогтоолын төслүүдийг тусгах зарчмыг баримтлан хэлэлцэж, асуудлын жагсаалтад нийтдээ 62 хууль,

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

тогтоолын төслийг тусган та бүхэнд тараасан байгаа.

Мөн хэлэлцүүлгийн шатад байгаа болон Монгол Улсын Их Хурлын 23 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлбэл хэлэлцэх асуудлын дараалалд оруулах асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэхээр, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль, тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 20 оны 02 дугаар тогтоол, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолд туссан хууль тогтоомжийн төслүүдийг Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар зохицуулсан болно.

“Монгол Улсын Их Хурлын 23 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Эрхэм гишүүд ээ, “Монгол Улсын Их Хурлын 23 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцсэн тогтоолын төслийг бас баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу.

Батжаргал гишүүнээр тасаллаа. Дашидондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Ганбат: Би тэр өнөөдөр Их Хурлын чуулганы эхэнд хэлсэн байгаа. Энэ үер усны гамшигтай, энэ авлигын нөхцөл байдал үүгээрээ илэрч гарч байгаатай холбогдуулаад хэдэн үг хэлсэн. Их л сандраад л байж ядаад байх шиг байх юм. Ингээж болохгүй л дээ. Үүнийг дагалдаад бас үргэлжлээд үүний дараа аягүй л бол энэ өвчин зовлон гээд хяналтаас гарна шүү. Ялангуяа энэ хүүхдүүдийн өвчин зовлон бол хэтэрдэг. Энэ муухай хөрс шороо, энэ бүх юм чинь, агаар энэ юм нь тархана шүү. Энэ дээр нөхдүүд анхаармаар байна.

Намрын чуулганаар хэлэлцэх асуудлын юунд сая энэ удаж удаж байгаад, хүлээж хүлээж явж явж байж нэг юм Монгол Улсын Ерөнхий сайд энэ урд хөршид очиж айлчлал хийх шиг боллоо. Үүнтэй холбогдоод ямар мэдээлэл байна вэ. Үүнтэй холбогдоод хэлж ярих, хэлэлцэх асуудал энэ намрын чуулганаар байх уу, үгүй юу.

Би ялангуяа энэ хувийн хэвшилүүдийг, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих талаар энэ талаар юм орсон уу, байна уу. Энэ аль болохоор л юм хийж байгаа Монгол хүмүүсээ шахсан, Монголын ААН-үүдээ хавчсан ийм байдалтай байх юм. Түүний нэг жишээ нь би энэ Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг ярих гээд байна. Надад байгаа ганц нэг мэдээллээр бол энэ Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг энэ урд хөршийн нөхдөд өгөөд эндээс ирэх оныхоо сонгуулийн мөнгийг босгож байна гэсэн ийм мэдээлэл яваад байна. Өмнөх ажлаа дүгнэлгүйгээр ингээж явж болох юм уу, болохгүй юм уу.

Сая ковидын үеийн нөхцөл байдал энэ өнгөрсөн үед бол Эрдэнэтийн 49 хувийг арай гэж авчирсан, энэ л аминд орлоо шүү дээ гэх мэтчилний ийм нөхцөлүүд байна. Үүнийг мэдэж байгаа,

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

бодож байгаа, ярьж байгаа энэ ард нийтдээ мэдээлэх, ард түмний хэлж болсон энэ Улсын Их Хуралд бас бид нарт нэг тодорхой тайлбарлаад өгчих ийм юм байна уу, үгүй юү.

Баяр наадам болдгоороо л болно. Аягүй л бол энэ эрх барьж байгаа нөхдийн торгон дээлтэй, том машинтай яах, хамгийн сүүлийн наадам ч байж магадгүй. Гэхдээ битгий улайраад бай л даа, та бүхэн. Энэ чинь хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулна гээд бид нар Үндсэн хуульдаа заачихсан байгаа. Тэр Үндсэн хуулийнхаа зүйл заалтынхаа дагуу энэ орон гэргүй болчихсон, энэ хохирч байгаа, энэ авлигаас чинь болж энэ газар олголт, энэ хот байгуулалт, хэчнээн олон сайд дарга нар, хэчнээн олон яам Тамгын газар, хэчнээн олон газрууд байдаг билээ. Энэ юмыг тоохгүйгээр энэ ард иргэдийнхээ байгаа байдлыг хажуугаар нь нүдээ аниад өнгөрч байгаа маягтай энэ Улсын Их Хурал ийм байдалтай ажил төрлөө явуулж болохгүй байх гэж би бодоод байх юм.

Тэгээд юм хэлээд асуудлыг гаргаад энэ талаар санал хэлэлцье. Гишүүдийн саналыг хураалгая гээд би чуулганы хамгийн эхний үг хэлж зөвшөөрөл аваад хэллээ. Энэ дээр миний хэлсэн тэр санал гаргасан юугаар хураалгачхаж болдоггүй юм уу? Нэг ч гэсэн иргэнээ бид нар бодож байх ёстой шүү дээ. Нэг байтугай хэдэн мянган иргэн хохирчлоод байна. Өөрийнхөө өмч хөрөнгөөр, өөрийнхөө эрүүл мэндээр, амь насаар тэр онцгой байдлын түрүүчийн албан хаагчид л гэхэд өнөөдөр амь эрсэдсэн байна. Тэд нарын багаж, тоног төхөөрөмж нь ямар байна? Тэд нарын ажиллах нөхцөл нь ямар байна? Энэ бүгдийг бид нар авч хэлэлцэх ёстой шүү дээ. Ямар ч бэлтгэлгүй байгаа нь ингээд харагдаад байна. Энэ дээр бид нар ингээд ийм харгис, ийм хүний үнэргүй, ийм бас Улсын Их хурал байж болохгүй шүү дээ.

Үндсэн хуульд уул нь заачихсан байгаа л даа. Тэгээд тэр хувийн хэвшил, эх орон, энэ Монгол Улсын ААН-үүдийг хөрөнгө оруулалтыг нь дэмжинэ гэж байхгүй, унагаж байдаг. Тэгээд гаднын хүмүүст түүнийгээ өгчихдөг, тэр нь ямар ч ажил хийх ... /минут дуусав/

Г.Занданшатар: Байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Бид нар 23 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлуудынхаа талаар ярьж байгаа. Би сая Байнгын хорооны танилцуулга дээр хэлсэн. Ямар ямар зарчмууд, ямар ямар түрүүнд нь гарсан эрх зүйн баримтуудаа баримталсан гэдгээ хэлсэн. 3, 4 үндэслэлүүдээ хэлсэн. Энэ дотор яг Ерөнхий сайдын Хятадад айлчилсантай холбоотой асуудлаар одоогийн байдлаар энэ айлчлалын дүнгээр ийм ажил хийнэ гэсэн тодорхой саналууд Байнгын хорооны хуралдаан болох үеэр манай дээр ирээгүй. Мэдээж гэрээ хэлцлээ хийчихсэн асуудлуудыг цэгцлээд, албажуулаад, баталгаажуулаад, заримд нь бас тодорхой хугацаа шаардагддаг. Тэр ороод ирэх байх. Тэр үед нь холбогдох Байнгын хороогоор дээр нь хэлэлцээд явах асуудлууд нээлттэй байж байгаа. Тухай бүрд нь ийм асуудлуудаа хэлэлцээд явах. Яг сая бид нарыг хэлэлцэх үеэр Ерөнхий сайдын айлчлалын үр дүнгээр ийм ажлууд хиймээр байна, ийм тогтоол гэсэн, ийм хууль гэсэн санал орж ирээгүй байсан, Ганбат гишүүн ээ. Гэхдээ мэдээж эд нар яригдаж таарна. Тухай тухайд нь Засгийн газраас бусад шугамаар гишүүд санаачлаад ороод ирвэл хэлэлцээд явах боломжууд нь тогтоол дээр бичигдчихсэн байж байгаа.

Г.Занданшатар: Дашидэндэвийн Ганбат гишүүн тодруулж асууя. Нэг минут.

Д.Ганбат: Энэ намрын чуулганаар ярих энэ Улсын Их Хурлаар хэлэлцэх хуулиуд, тогтоолын төслүүд

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

дээр энэ дотоодын хөрөнгө оруулагчдыг, энэ хувийн хэвшилээ дэмжих, дэмжсэн, дотоодын хөрөнгө оруулагч, тухайлбал Худалдаа үйлдвэрийн танхим, энэ ААН-үүдээсээ асуугаад ямар хууль тогтоомжийг бид нар хэлэлцвэл та нарын ажил төрөлд дөхөмтэй байна вэ гэсэн ингэж асууж, лавлаж ингэсэн зүйл байгаа юу, байхгүй юу?

Нөгөө талаар энэ хэдэн хувийн хэвшилүүд чинь чадан ядан нэг жоохон хуримтлалтай болчихсон юм шиг байгаа юм, сүүлийн хэдэн жилд. Энэ хуримтлалаа тухайлбал би Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг ярих гээд байна л даа. Энэ нэлээн мөнгө төгрөг хийгээд, нэлээн ажил нь зүгшрэх гээд чадан ядан байсан юмыг энэ цаашидаа хэнд хэнд өгөх гээд байна, ямар байдлаар явуулах гээд байна. Энэ ажил нь хэвийн явж байна уу, үгүй юу? Үүнийг бид нар ингээд тоохгүй хаяад, орхиод явж байгаа гэх мэтчилний зөндөө зүйлүүд байна л даа. Надад хугацаа бага болохоор би ... /минут дуусав/

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга.

Н.Энхболд: Би түрүүн танилцуулга дотроо хэлсэн. Байнгын хороодоос 51, Засгийн газраас 106, Ардын намын бүлгээс 27, Ардчилсан намын бүлгээс 27, Их Хурлын гишүүдээс 2 санал ирсэн байсан. Нийтдээ 213 хууль, тогтоолын төсөл яриулж байгаад бид нар энэ жагсаалтыг гаргасан. Мэдээж энэ дотор тухайлбал ялангуяа Монгол Улсын Засгийн газраас орж ирсэн 106 хууль, тогтоол эрх зүйн зохицуулалтуудын талаарх баримт бичгүүдийн юман дотор хувийн хэвшлийг дэмжих, хувийн хэвшилтэй хамтарч ажиллах төрийн зарим чиг үүргийг хувийн байгууллагуудаар, ТББ-аар хийлгэх гээд олон саналууд гарч ирсэн. Энэ жагсаалт дотор зарим нь туссан байгаа.

Би зүгээр 2, гуравхан зүйлүүдийг хэлчихье. Сая Ганбат гишүүний

асуусантай холбогдуулаад. Жишээ нь Арилжааны тухай хуулийн төсөл гээд нэлээн том хууль дотор явж байгаа. Ашигт малтмалын тухай хуулийн төсөл бол үндсэндээ ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчихъя. Нямаагийн Энхболд гишүүн, Байнгын хорооны дарга.

Н.Энхболд: Үндсэндээ хувийн хэвшилээр төр дангаараа үүнийг хийгээд байж болохгүй, хувийн хэвшилтэй хамтарч эс үгүй бол хувийн хэвшилээр хийлгэх ажлуудын талаар гол зүйлүүд энд туссан байгаа гэж ойлгож байгаа. Өрсөлдөөний тухай хууль байна, шинэчилсэн найруулга. Энэ бол өөрөө бас бизнесийнхнийг дэмжих, шуударга өрсөлдөөнтэй байх, төр бизнесийн ажилд хажуугаар нь өрсөлдөж орохгүй байх тухай гэх мэтчилэн томоохон суурь асуудлуудыг тусгасан хуулийн төслүүд орж ирэх байх гэж бодож байна. Ямар ч байсан ингээд биччихсэн байгаа. Энэ чинь зарим нь зүгээр саналаа ирүүлчихсэн, төсөл нь ирээгүй ийм л хуулиуд байгаа шүү дээ. Тэгээд ингээд зун тэгээд чуулган эхлэх үед түрүүчийн хуулиуд ирнэ. Өргөн баригдчихсан хуулиуд байгаа, ингээд хэлэлцээд явна л гэж бодож байна.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ удаагийн хаврын чуулган ингээд хаалтаа хийж байна. Тэгээд тун удахгүй Монгол түмэн маань дэнж хотойтол сайхан наадна. Ингээд зуны амралт дуусаад энэ намрын чуулган удахгүй эхэлнэ. Тэгэхээр энэ намрын чуулган бол, ирэх намрын чуулган бас чухал хариуцлагатай ийм чуулган болно гэж ингэж үзэж байгаа. Тэгээд энэ дотор нэг хэдэн тодруулах асуулт байна.

Юу гэхээр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дотор бас энэ дагаж мөрдөх хуулиуд, дагаж гарах хуулиуд дотор энэ Баялгийн сангийн тухай хууль гээд. Энэ хууль орж байгаа

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

юу? Яагаад гэхээр энэ Баялгийн сан гэдгийн энэ хуулиа бид нар баталж, бас олон асуудлуудыг эндээ хамруулж, саяын энэ Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Боловсролын ерөнхий хууль болон багц хуулиуд дотор гарч байгаа дагалдаж гарах маш их зардлууд байгаа.

Дээрээс нь тэтгэвэр, цалин энэ тэр нэмэгдэхтэй холбоотой бас зардлууд байгаа. Хүүхдийн мөнгө гээд. Энэ асуудлуудыг бас тодорхой хувийг нь энэ баялгийн сангийн хуулийг баталж бас уялдуулж өгмөөр ингэж санагдаад байгаа юм. Тэгэхээр энэ хууль орох уу гэдэг нэг асуудал.

2 дугаарт, энэ Нийгмийн даатгалын багц хууль маань бас сая явсан. Тэгээд бид нар бас гишүүд орон нутагт ажиллах хугацаандаа нийгмийн даатгалын олон давхаргад тэтгэврийн тогтолцоотой болно гэж ингэж ярьж явсан. Тэгээд энэ хууль ингээд батлагдаад гараад ирэхээр харахад олон давхаргат биш хуучнаараа л яг нэг давхаргатай байхаар ингээд харагдаад байгаа. Яагаад вэ гэхээр энэ хагас хуримтлалын тогтолцоо буюу суурь тэтгэврийн асуудлыг бас шийдээгүй учраас энэ 3 давхаргатай ядаж болгоно гэж байсан асуудал ингээд орхигдож байна.

Тэгэхээр энэ дээр энэ хувийн нэмэлт, хувийн тэтгэврийн сангийн тухай хууль маань хэзээ орох вэ. Энэ багц хуулиасаа ингээд үлдчихлээ. Ядаж Хувийн тэтгэврийн сангийн тухай хууль ороод явбал энэ 2 давхаргатай, өөрөөр хэлбэл иргэдэд маань энэ сонголттой болох ийм асуудал байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг энэ хэлэлцэх асуудал дотор байгаа юу, аль хэсэгт нь хамарч явж байгаа вэ гэдэг ийм 2 дахь асуулт байна.

3 дугаарт нь, бид нар энэ ХАА-н салбарыг эдийн засгийн 2 дахь том салбар, маш олон хүн ажиллаж амьдардаг ийм салбар. Тэгээд энэ сая энэ Нийгмийн даатгалын ерөнхий хууль

дотор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль энэ тэр дотор энэ малчдын НДШ-ийн тухай асуудал орж ирэхээр энэ хүмүүс бас буруу ойлголттой эмзэглээд байх шиг байна. Энэ секторт маш олон 100 мянган хүн ажиллаж байгаа. Эргээд энэ хүмүүс бас энэ сан руу хамрагдаад ороод ирвэл энэ хүмүүсийг бас НДШ-ийг нь төлдөг болгочихвол улсын энэ нийгмийн даатгалын санд, тэтгэврийн санд өгдөг ачаа хүртэл буурах юм байгаа юм. Энэ талаас нь бас ерөөсөө сайн ойлгохгүй байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас ч гэсэн энэ малчдын сектороо та бүхэн энэ НДШ төлөлт рүү татаад ороод ирвэл их том ахиц гарна гэж ингэж зөвлөж байгаа. Тэгэхээр энэ асуудлуудыг дагаж явах ёстой энэ асуудлуудыг ч гэсэн яг ингэж ойлгож сая баталсан. Тэгээд үүний дараагийн тэр хэсэг нь Хувийн тэтгэврийн сангийн хууль бас ямар зүйл дээр байгаа вэ гээд.

Бас нэг тодруулж асуух асуудлууд энэ Дарханы арьс ширний цогцолбор, ганцхан Дарханы ч гэлтгүй дээ энэ ХАА-н гаралтай түүхий эд бүтээгдэхүүн дээр малчдын бэлдэж өгсөн энэ хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэглэгдэх түүхий эд бүтээгдэхүүнүүдийг үнэ цэнгүй болчихоод байгаа юм. Ямар ч үнэгүй, хог хаягдал болчихоод байна. Үүнийг боловсруулах ажлыг манай улс байна даа, нэг юм хийчихмээр байгаа юм. Тэгэхээр энэ асуудал маань намрын чуулганы хэлэлцэх асуудалд орсон уу гэсэн ийм 3 асуултыг асууя.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга хариулъя.

Н.Энхболд: Би түрүүн хэлсэн. Нөгөө энэ жагсаалтыг гаргахдаа ямар ямар зарчмууд баримталсан бэ, ямар дараалал барьж байх вэ гээд. Тэгэхээр энд хэд хэдэн зүйлүүд байгаа. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтдөө хууль тогтоомжуудаа нийцүүлэх тухай асуудал түүнтэй холбогдуулж авах арга хэмжээний тухай тогтоол байгаа. Үүний

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

дагуу тухайлбал таны асуусан Үндэсний баялгийн сангийн тухай хууль нэрээрээ орчихсон явж байгаа. 48 дээр байгаа жагсаалтад.

2 дугаарт, хэлэлцүүлгийн шатад байгаа эс үгүй бол сая гарсан саяхан баталсан жишээ нь хуулиудыг дагаад гарах асуудлуудыг тухай тухай бүрд нь хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэхээр ингээд заачихсан байгаа. Энэ дотор жишээлбэл сая даатгалын багц хууль ярьсантай холбогдуулаад араас нь ерөнхийдөө Их Хурал санал нэгдсэн юм, юу гэвэл тэр хувийн даатгалын тогтолцоог бас цааши нь үргэлжлүүлэх боловсронгуй болгох асуудал байгаа шүү дээ. Энэ байдлаар би оруулж боловсруулж оруулж ирнэ байх гэж бодож байна. Үүнийг тэр тухай бүрд нь шийдээд явах асуудал дотор оруулаад хэлэлцээд явах ийм бололцоо байж байгаа. Зориуд ийм уут тогтоол дотор гаргаж өгсөн.

3 дахь нь, Дарханы үйлдвэрийн талаар энэ дээр тодорхой зүйлүүд байхгүй. Тэгэхдээ тэр нэгэнт эхэлчихсэн явж байгаа цаашид хэрэгжүүлэх ёстой ажлаа Засгийн газрын зүгээс бас тухайн үед нь үйлдвэрээ ингээ, хөрөнгөө ингээ гээд ингээд шийдээд шийдээд явах нь бололцоо нь байгаа. Яг энэ жагсаалт доор Дарханы үйлдвэрийн тухай асуудал гэж байхгүй. Засгийн газраас оруулж ирэх зүйлүүд дотор багтана гэж ойлгож байгаа. Тийм.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний төсөл орж ирээд танилцагдаж байна, танилцлаа. Хэд хэдэн зүйлийг бид анхаармаар байна.

1 дүгээрт, бид яах аргагүй энэ хэрэглэгч улс орныг үйлдвэрлэгч улс орон болгох ёстой. Ингэхийн тулд энэ Хүнд

үйлдвэрийн тухай хууль, Хөнгөн үйлдвэрийн тухай хуулиа оруулж ирж энэ баялаг бүтээдэг салбар, ер нь энэ ХАА-н салбарынхаа ашиг шим, түүхий эд, энэ уул уурхайн салбарынхаа түүхий эдүүдийг улс эх орондоо боловсруулдаг, нэмүү өртөг шингээдэг, ажлын байр бий болгодог, валютынхаа дотогшилох урсгалыг нэмэгдүүлэх, тэгээд эдийн засгийнхаа тэлэлтийг хангах гээд олон чухал ач холбогдол байгаа учраас энэ хүнд, хөнгөн үйлдвэрийн салбарын хуулийг оруулж ирж энэ намрын чуулганаар батлах нь хэрэгтэй байх гэж ингэж бодож байна. Үүнийг юу гэж үзэж байна вэ гэж.

2 дахь зүйл, төрийн нийтийн болоод энэ тусгай өмчийн асуудлыг бид энэ нэлээн сайн анзаарч, нэг мөр сайн зохицуулалт хийх зайлиггүй шаардлага байгаад байгаа юм. Тийм учраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн болоод өмчийн оролцоот компаниудын тухай хуулийг яаралтай батлах зайлиггүй шаардлага байна. Ингэж байж энэ заяагдмал баялаг дээр тулгуурлагдсан үнэ цэнтэй энэ аж ахуйнуудын хувьцаа эзэмшигчдийн хувьцааны ноогдол ашиг юмнууд олгогддог. Олон нийтийн оролцоо хяналт сайжирдаг, тэгж байж үр өгөөж өсдөг. Ийм байх бололцоо байна. Тийм учраас энэ өмчийн харилцаа, компанийн харилцааг зохицуулсан хуулийг оруулж ирж батлах нь зөв юм болов уу гэсэн ийм санаа байна.

3 дахь зүйл, ХАА-н биржийн тухай хуулиа хэдүүлээ баталмаар байна. Энэ ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт, нийлүүлэлтийн ерөнхий сүлжээг тогтооход энэ хууль их чухал үүрэг гүйцэтгэнэ. Бид Уул уурхайн биржийн тухай хууль батлаад ямархуу хэмжээний ач тус гарч байна вэ, ямар үр өгөөж нэмэгдэж байна вэ гэдгийг сая тодхоноо харсан. Тийм учраас энэ ХАА-н биржийн тухай хуулиа оруулж ирж, намрын чуулганаараа баталбал бид бүхэнд, энэ ХАА-н салбарын маань

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

хөгжилд, энэ үйлдвэр аж ахуйн газруудын чанартай түүхий эд хангалтад, төв суурин газрын иргэдийн хүнсний хангамж аюулгүй байдалд ихээхэн том үүрэг гүйцэтгэнэ гэж ингээж үзэж байна.

Дараагийн нэг асуудал нь Баялгийн сангийн хууль ороод ирчихлээ. Мэдээж тэгэхээр үүнийг дагасан бид үндэсний хуримтлалынхаа асуудлыг зөв харах хэрэгтэй байна. Дан дамаа 24 оны төсвийн төсөл боловсрогдож орж ирнэ. Энэ хүүхдийн мөнгийг халамжийн мөнгө гэж ярьдгаа болимоор байна. Энэ хүүхдийнхээ хөгжлийг дэмжсэн баялгийн хуваарилалтын хуримтлал байх ёстой. Тийм учраас энэ хүүхдийн мөнгөний тодорхой хэсгийг Үндэсний хуримтлал хүүхдүүдийнхээ нэр дээр болгох тухай асуудал, саяын батлагдсан энэ Нийгмийн даатгалын багц хуультай холбогдуулж нийгмийн даатгалын нэрийн дансны үлдэгдлийг хуримтлалынхаа бас нэг бүрэлдэхүүн хэсэг болгож авч явах тухай асуудал.

3 дугаарт нь, сая энд Туваан хөндөнө лээ. Тэр Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийг оруулж ирж батлаад бас тодорхой хэмжээний иргэд ирээдүйнхээ нийгмийн баталгааг хангах, хөрөнгийн хуримтлал үүсгэх түүнийг нь бас үндэсний хуримтлалынхаа бүрэлдэхүүн хэсэг болгож авч явж, ерөөсөө энэ улс орныхоо хөгжил, баялаг бүтээх салбарынхаа хөгжлийг хангаад ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хөөе, гишүүд тайван байцгаа. Хөөе, тийм Үнэнбат бид 2 яриад Төрийн байгуулалтын байнгын хороо гээд зарлачихсан юм. Биш биш. Нямбаатар сайд. Хөөш Хууль зүйн байнгын хороо тэгвэл хуралдах болов уу, Хууль зүйн байнгын хорооны ирц байгаа юм уу? Тэгвэл Даргын дэргэдэх зөвлөл дээр төрийн байгуулалт гээд л тавьчихаар нь би тэрийг тэгээд засчихсан шүү дээ. Тэгвэл даргын

дэргэдэх зөвлөл дээрхээ Хууль зүйн байнгын хороо болгоод өөрчил.

Батжаргал гишүүн санал хэлчихлээ. Баагаагийн Баттөмөр гишүүн. Төрийн байгуулалтаар явчихад болохгүй байгаа юм уу.

Б.Баттөмөр: Энэ намрын чуулганаар хэлэлцэх асуудал бол их чухал. Энэ дээр маш их олон асуудлууд байгаа. Хамгийн 1 дүгээрт нь би энэ Шинжлэх ухаан, технологийн хуулийг энэ намрын чуулганаар хэлэлцэж батлах ёстой. 2, 3 хувилбараар энэ Их Хуралд өргөн баригдчихсан байгаа. Бидний хэд хэсэг гишүүд өргөн барьсан байгаа. Дээр нь энэ яамнаас бас өргөн баригдсан байгаа. Ингээд хойшлоод яваад байдаг. Энэ орчин үед шинжлэх ухаандаа анхаарлаа тавьж, шинжлэх ухаандаа мөнгөө хаяж, шинжлэх ухаанаа урд талдаа авч явж байгаа улсууд хөгжиж байна шүү дээ. Тэгэхээр бид нар үүнээс хойш сууж ерөөсөө болохгүй. Үүнийг энэ намрын чуулганаар зайлиггүй хэлэлцэж батлах ёстой. Энэ дээр мэдээж өргөн баригдаад бидний барьсан, өргөн баригдсан 2 жил шахуу болчихлоо. Энэ хугацаанд дэлхий ертөнц шинжлэх ухааны орж байгаа, бий болж байгаа энэ ололт амжилт асар их хурдацтай өөрчлөгдөж байгаа. Тийм учраас энэ 2-ыг нийлүүлээд шинэчилж ажлын хэсэг байгуулаад, энэ хуулийг батлах ёстой гэж ингээж бодож байгаа.

Дараагийн асуудал энэ Алсын хараа 2050 гээд хөгжлийн баримт бичгийг бид нар бас баталсан. Үүний эдийн засгийн хэсэгт нь би бас орж ажилласан. Энэ үндсэндээ буцаад хуучирчихлаа, одоо 4 жил болох гэж байна. Тэгэхээр үүнийгээ бид нар энэ юу яах ёстой энэ Алсын хараа 2050-ийг чинь хөгжлийн загвар гэж үзээд байгаа юм шүү дээ. Үнэхээр хөгжлийн загвар гэж үзэж байгаа юм бол үүнийгээ шинэчлэх хэрэгтэй. Монгол Улс ямар хөгжлийн загвараар хөгжих гээд байгаа юм. Энэ өнөөдрийг хүртэл тодорхойгүй байгаа шүү дээ. Хуримтлал байхгүй хөгжилд нь,

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

хурд байхгүй нэг либерал загвар энэ улсууд нь яриад байдаг. Ардчилсан гэх орнуудад энэ либерал загвар хэрэгждэг. Гэтэл ардчилал маань өөрөө хямралд орчихлоо гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байгаа. Тийм учраас Монголд хөгжлийн энэ хурдтай, хуримтлалтай, баялаг дээрээ суурилсан ийм хөгжлийн загвар байх ёстой. Ийм учраас энэ 2050 хөгжлийн баримт бичгийг шинэчлэх ийм шаардлага үүсэж байна гэдгийг бас хэлье гэж.

Дараагийн асуудал энэ Монгол Улсад энэ далд эдийн засаг гэдэг юм, үнэхээр хүчээ авчихсан, асар хүчтэй, энэ дээр тоо баримт хийх юм бол, хэлэх юм бол асар их олон тоо баримт хэлмээр байна. Ийм учраас энэ Татварын хуульдаа өөрчлөлт оруулах, татварын бүртгэлийг сайжруулах, татвар төлөхөөс зайлсхийсэн хүмүүст хүлээлгэх хариуцлагыг чангатгах, татвар төлж байгаа хүмүүстээ урамшуулал олгох ийм эрх зүйн харилцаануудыг бий болгох ийм шаардлага зайлшгүй байна гэж ингэж үзэж байгаа юм.

Бид нарын яриад байгаа энэ Баялгийн сан гэж байгаа юм. Төсөв их төлчихлөө гээд л зарим хүмүүс гаслаад байх юм. Төсөв тэлэхгүй тэр бага хэмжээнд нь байлгах гээд байгаа юм бол тэр нэмж орж ирэх энэ хуримтлалаа, баялгийн сандаа хуримтлуулаад ирээдүйдээ хөрөнгө оруулах хэрэгтэй. Энэ гол гол тулгамдсан асуудлууддаа хөрөнгө оруулъя, энэ өр зээлээ төлье. Энэ Баялгийн сангийн хуулийг батлах ёстой.

Дараагийн асуудал энэ Худалдааны хууль. Монгол Улс 32, 3 жил Худалдааны хуульгүй явлаа. Тэр өөрөө хийсэн бүтээгдэхүүнээ ямар үнээр худалдах нь тухайн асуудал байна. Баялаг дээр асар олон үнэ байна. Тухайн компани бол зөвхөн өөрийнхөө эрх ашгийг бодож, одоо ашигт малтмалыг гадаадад худалддаг, худалдааны нэгдсэн бодлого байхгүй, бодлогоор энэ дотоод зах зээлээ

хамгаалах ийм шаардлагууд үүссэн байна шүү дээ.

Тендерийн хууль байна. Тендерийн хуулийг өөрчлөх ... /минут дуусах/

Г.Занданшатар: Санал хэллээ. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн. Дараа нь санал хураалттай гишүүд ээ.

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Баярлалаа. Энэ намрын чуулганаар хэлэлцэх асуудал орж ирж байна. Миний бие энэ улсын эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэх энэ Худалдааны хуулийн төслийг, ажлын хэсгийг миний бие ахлаад сүүлийн 2 жилийн хугацаанд ажиллалаа. Тэгээд өнгөрсөн 30 жил энэ худалдааны салбар нэгдсэн хууль ийм хуулийн зохицуулалтгүй явж ирсэн. Улс орны гадаад, дотоод орчин, нөхцөл байдал, энэ эдийн засаг, үнийн өсөлт, инфляцид чухал үүрэг гүйцэтгэх энэ хууль бас энэ Худалдааны хууль юм. Тийм учраас энэ хуулийг бас намар оруулж ирэх шаардлагатай байна гэж үзэж байна. Ер нь манай улс энэ 16 онд Дэлхийн худалдааны байгууллагын худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг баталсан байдаг. Гэтэл энэ хэлэлцээрээр хүлээсэн үүрэг, амлалтаа хэрэгжүүлэх хуулийг батлаагүйгээс энэ хэлэлцээрийн хэрэгжилт бол бүс нутгийн түвшинд дунджаас доогуур үнэлгээтэй яваад байгаа юм. Тиймээс энэ нэгдэж орсон хэлэлцээрүүдэд бид нар олгогдсон энэ боломжийг аль болохоор үр дүнтэй интеграцлагчдах бүрэн дүүрэн ашигладаг баймаар байгаа юм. Тэгээд энэ хамгийн эхний алхам бол энэ эрх зүйн орчныг дотооддоо бүрдүүлэх асуудал хамгийн чухал байгаад байгаа юм. Тэгээд ер нь бид нарын энэ манай ажлын хэсэг өнгөрсөн хугацаанд энэ салбар бүрийн эрдэмтэд, судлаачид, холбогдох төрийн байгууллагууд оролцож энэ олон улсын туршилага, тэдгээрийн эрх зүйн орчныг харьцуулан судалгаа хийсэн байж байгаа.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулж ер нь бас тодорхой түвшинд цаашидаа бас олон нийтээр хэлэлцүүлэхэд ийм боломж нь бүрдсэн байж байгаа. Тэгээд энэ хуулийн гол ач холбогдол нь өнөөдөр иргэн экспортлогч болохоос өгсүүлээд дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд өнөөдөр Монгол Улс өөрөө брэнд болох ийм боломжуудыг бүрдүүлсэн ийм хуулийг боловсруулсан байж байгаа.

Нэгэнт худалдааны асуудал хариуцсан бие даасан яамтай болсон, агентлагтай болсон учраас Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогоор дэвшүүлсэн зорилтууд, ялангуяа энэ Шинэ сэргэлтийн бодлогын зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд энэ худалдааны эрх зүйн орчныг бол энэ бодлогын түвшинд нэгтгэж бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Тэгээд энэ ажлын хэсгээс боловсруулсан энэ хуулийн төсөл, холбогдох бүхий л судалгааг Эдийн засгийн хөгжлийн яамны Хүрэлбаатар сайдад хүргүүлсэн байж байгаа. Тэгээд сайдын зүгээс Улсын Их Хурлын ажлын хэсэгтэй зөвшилцөөд энэ хуулийн төслөө өргөн бариад ингээд цаашидаа ингээд хамтраад ингээд ажиллаад явна гэж найдаж байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд энэ Худалдааг дэмжих тухай хуулийг оруулж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт явуулна, гишүүд. Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы

танхимд хүрэлцэн ирээрэй. Санал хураалт явуулж болж байна уу?

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 23 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батална. Санал хураалт явуулъя.

Одоо наад асуудлаа шийдэхгүй бол Хууль зүйн хүрээлэнгийнхэн чинь цалингаа авч чадахаа больчихоод байгаа байхгүй юу. Манайхаас өгч болохгүй байгаа байхгүй юу. Засгийн газар шийдвэр гаргах ёстой. Тэгэхээр Засгийн газар саяын саналыг оруулж ирж байгаа юм. Өлзийсайхан дарга та л болохгүй гээд байсан. Тэгэхээрээ тайлбарла даа. Болох юм бол хамаа алга, тэгвэл, хэлэлцэхгүй л.

Мягмар дарга аа, та 2 яриадах даа, тэгээд хэрвээ хуралдахгүй бол, хуралдахгүйгээ хэл, болохгүй байна гэсэн. Тэгээд болох юм бол тэгээд хамаа алга. Үгүй ээ, энэ Сангийн яам нь тогтоолд нэг заалт оруулаад энэ цалинг нь өгөх бололцоотой байж байгаа. Тэгэхгүй бол энэ чинь Хууль зүйн яамны ажилтнууд байгаад байгаа байхгүй юу. Үндсэн хууль батлагдсантай холбогдуулж гэж тогтоол санаачилсан байна лээ.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

56,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Одоо ямар ч байсан Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаад, нэгтээ зарлаад, Даргын дэргэдэх зөвлөлөөр бүгд дэмжээд баталчихсан шүү дээ. Бүх гишүүд 100 хувь

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

баталчихсан байна лээ шүү дээ. Тэгээд үнэхээр хэлэлцээд нь тэгээд болох, болохгүй юмаа яриад, тэгээд шаардлагатай гэвэл Хууль зүйн байнгын хороо хуралдуулъя. Тэгээд ер нь цагийн нөхцөл байдал ийм байхад өнөөдрийн арга хэмжээг ч гэсэн үндсэндээ цуцалсан ч болохгүй юм, Ардчилсан намын бүлэг ч гэсэн тийм арга хэмжээ байгаад байна шүү дээ.

Ингээд Төрийн байгуулалтын байнгын хороо завсарлаад хуралдчихъя. Хуралдаад юмыг нь сонсчихъё.

12.47 цаг

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 07 дугаар сарын 07-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Одоо хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөр санал нэгтгэйгээр энэ асуудлыг хэлэлцэх асуудлын дараалалд нэмж оруулаад, сая Төрийн байгуулалтын байнгын хороогоор хуралдан шийдвэрлэсэн болно.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн

Хишгээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн албан тоот бичгээр ирүүлсэн саналын дагуу “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй уялдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасныг баримтлан боловсруулж, Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд, хууль тогтоомжийн төсөлд дүн шинжилгээ хууль зүйн судалгаа хийх чадавхыг сайжруулах, парламентын судалгааны албыг өргөтгөн зохион байгуулах зорилгоор “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 44 дүгээр тогтоолын 3 дахь заалтад заасан арга хэмжээний хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн барилгыг Улсын Их Хурлын Тамгын газарт шилжүүлэн авах арга хэмжээг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт, мөн тогтоол баталсантай холбогдуулан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой 2023 оны 07 дугаар сараас 12 дугаар сарын зардлыг өмнөх түвшинд нь тооцож, Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны батлагдсан Төсвийн багцаас санхүүжүүлэх арга хэмжээ авахыг тус тус даалгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд хуралдаанд

оролцсон гишүүдийн олонх нь Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Сангийн яам тохирсон юм байна. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Жамбын Батсуурь гишүүнээр тасаллаа. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүнээр тасаллаа. Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Би энэ Монгол Улсын Үндсэн хуульд оруулж буй өөрчлөлттэй холбогдуулан ахуйн арга хэмжээний тухай тогтоолуудыг дэмжихгүй байна. Энэ ер нь Ардын намынхан энэ ТӨК-аар дамжуулаад Монголыг одоо ер нь бүгдийг авлаа. Энэ хувийн өмч гэж байхгүй боллоо. Хуулийн засаглал ч гэж байхгүй боллоо. Одоо хавь ойрд байгаа бүх байшингуудыг бүгдийг нь Их Хурлын тогтоол гаргаад авчихлаа. Байшингаа өгөхгүй гэнгүүт нь дотор нь байгаа хүмүүстэй нь ингээд авчаж байна. Энэ бол би болж бүтэхгүй асуудал гэж ойлгож байгаа. Ер нь яахаараа энэ төрийн эсрэг, эсрэг нь юу байх вэ? Төрд хөндлөнгөөс үгээ хэлдэг нийгмийн бүлэг, фракцууд яагаад байж болдоггүй юм. Хууль зүйн хүрээлэнгээ яагаад байж болдоггүй юм. Заавал энэ төрд авчраад та нарын лантуун дор та нарын хэлснээр дуугарч байх ёстой юм уу. Ер нь сайн байна бүгдийг нийгэмчилчихвэл яасан юм. Өнөөдөр авлига, хээл хахууль, өнөөдөр энэ гадаа байгаа үер бас юунаас болсон юм. Авлига, хээл хахуулиас, авлига хээл

хахууль хаанаас болдог юм. Төрийн дарангуйллаас л болж байгаа шүү дээ. Хэрвээ тэнд архитектурын байгууллага нь, хөндлөнгийн хяналтын байгууллага нь, газар олгодог байгууллагад нь олон нийтийн оролцоо байсан бол өнөөдөр энэ авлига бий болох уу, авлига хороолол бий болох уу? Харж байгаад өөрсдөө бариулчихаад ус оронгуут нь дэргэд нь очиж нураая энэ тэр гээд матрын нулимс гаргадгаа боль л доо та нар.

Тэгээд одоо энэ ордон тойрсон бүх байшингуудыг худалдаад авчих юм байна л даа. Тэгээд байшингаа өгөхгүй бид нар ажиллах нөхцөл бололцоогоо хангуулахгүй гэнгүүт нь хүнтэй нь худалдаад авчаж байгаа байхгүй юу. Яасан их мөнгөтэй юм. Өнөөдөр Эрдэнэс тавантолгой, Оюутолгой, Эрдэнэт, төрийн өмчийн гар хөл очиж, төрийн өмчийн хумс хуруу тэнд очсоноос болж л энэ авлига чинь цэцэглэж байгаа шүү дээ. Тэгээд энэ авлигын хор хохирлыг Монголын ард түмэн бүгдээрээ үүрч байна шүү дээ. Одоо хөндлөнгөөс үг хэлдэг хуульчид, хуульчдын одоо Хууль зүйн үндэсний хүрээлэн гээд тэнд бас нэг арай нэг өөр дуугардаг, арай нэг өөр санаатай энэ хүмүүсийн амыг хааж байна шүү дээ. Энэ Тамгын газарт орж ирчхээд энд та нарын өөдөөс үг хэлнэ ээ, ёстой гонж доо. Далайсан газар чинь далд орж, далласан газар чинь ил гарч л явна. Ингээд бүгдийг хумиад одоо тэр коммунист систем рүүгээ орох юм байна л даа. Тэр байтугай, одоо АН-ын яриад байгаа энэ олон нийтийн хараа хяналтад энэ төрийн өмчөө хурдан хувьчлаач дээ. Энэ байшин, барилгаа хувьчлаач дээ. Нөгөө тэр ч байтугай төрийн өмчийн барилгуудыг төр, хувийн хэвшилийн одоо түншлэлээр өгнө гээд ордны гуанз ортол хувийн болгож байсан, хувийн өмч дээр үйлчилгээг нь авч байсан энэ бүх үйлдлээсээ ухарч байгаа юм уу, ухарч байгаа юм уу. Одоо мөд энэ гуанзаа гуанзанд ажилладаг хүмүүстэй нь төрийн үйлчилгээний албан хаагч болгоод цалинжуулах байх л даа. Ингээд надад таарсан хоол хий, тэдний өдөр бэлэн бай

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

гээд ингээд бүгдийг цэрэг, цагдаа шиг болгож авах юм байна л даа.

Тэгээд энэ тогтоолыг чуулган завсарлаж байх сэмхэн Төрийн байгуулалтын байнгын хороогоор оруулж ирээд л тэгээд наадмын өмнө хамгийн сүүлд одоо та нар яаралзтал гараа өргөнө л дөө. Ингээд чуулган болгоны дараа төрийн өмчийг, хувийн өмчүүдийг бүгдийг ингээд хураагаад авах юм байна. Энэ үйлдлээ зогсоо та нар. Нөгөө аман дээрээ ярьдаг хувьчлал, хувийн өмчийг дэмждэг төр, хувийн хэвшлийн түншилэл хаана байна вэ. Юу ч байхгүй. Ингээд л наадам болонгуут, цагаан сар болонгуут, шинэ жил болонгуут нэг юм цөл хийтэл хийчхээд л тэгээд л бодож байсан боохой ... /минут дуусав/

Г.Занданшатар: Зүгээр Батсуурь гишүүн уг санаа нь зөв юм хэлж байгаа мэт боловч энэ чинь хувийн өмчийг 1 дүгээрт, авч байгаа зүйл биш ээ. Энэ чинь төрийн Хууль зүйн үндэсний хүрээлэн чинь Хууль зүйн яамны харьяаны, Хууль зүйн яамны харьяа байгууллага, төрийн албан хаагчид. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн энэ барилга чинь бас төрийн өмчийн байр. Нэг төрийн өмчийн эзэмшигч нараас бие биедээ л шилжиж байгаа асуудал.

Харин ч бүр Хууль зүйн холбоотой Улсын Их Хурлын Тамгын газар гэрээ байгуулаад, хууль тогтоомжид үнэлгээ хийдэг, тэдний дуу хоолойг тусгадаг, сонсгодог ийм хамтын ажиллагаа бүр харин өрнүүлж байгаа. Энэ бүр харин ард түмний, иргэдийн санал бодлыг илүү сонсгоход чиглэсэн багц, цогц ажил хийгдээд явж байгаа шүү дээ. Ийм асуудал юм шүү гэдгийг ойлгочихъё.

Ингээд санал хураалтад. Гишүүд асуулт асууж, хариулт авч. Юунаас Байнгын хороо нэмж хариулах байсан уу, үгүй юу, яах вэ.

Санал хураалт явуулъя. Тэгэхээр буруу ойлголттой яригдаад байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Одоо Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа.

13.28 цаг

Эцсийн найруулгуудыг сонсоно. Батлагдсан хууль, тогтоолын төслүүдийн эцсийн найруулгыг сонсоно.

Иргэний нисэхийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан, Иргэний нисэхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

найруулга дээр саналтай гишүүн байна? Алга байна. Сонссонд тооцлоо.

6. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

7. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төмөр замын тээврийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр

саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Төмөр замын тээврийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Боловсролын ерөнхий хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан, Боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

СӨБ-ын хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

4. Бага, дунд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дээд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

7. Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим хэсэг заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Гамигаас хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгон тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонсонд тооцлоо.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим заалт хэсгийг

хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ойн тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн

найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

21. Эрүүл ахуйн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

23. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хууль, тогтоолын төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дээд боловсролын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. сонссонд тооцлоо.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд сонссонд тооцлоо.

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

